**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2021 оны 10 сарын 12 өдөр Дугаар А/240 Мандалговь

"Хос соёмбот өргөө" ХХК-тай гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/193 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Дэлгэрхангай сумын онцгой комиссын хэрэгцээнд автомашин" нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Хос соёмбот өргөө" ХХК-тай 79,999,207 (далан есөн сая есөн зуун ерэн есөн мянга хоёр зуун долоо) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу "Дэлгэрхангай сумын онцгой комиссын хэрэгцээнд автомашин" нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Хос соёмбот өргөө" ХХК-ний гүйцэтгэх захирал (О.Эрдэнэбаатар)-т үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Дэлгэрхангай сумын Засаг дарга (М.Батсүх), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ

486211184